



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/412

Хэрлэн сум

Зөвлөгөөнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 2023 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 02, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.2.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Зүүн бүсийн тариаланчдын зөвлөгөөн-2024” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, ажлын гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
08 дугаар сарын 08-ны өдрийн
А/4/12 дугаар захирамжийн хавсралт

"ЗҮҮН БҮСИЙН ТАРИАЛАНЧДЫН ЗӨВЛӨГӨӨ-2024" ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Үүнээс		Тайлбар
						ЗДТГ	ХААН банк	
1	Сургалтын материал	х/тоо	120	24000	2880000	2880000		
2	Цайны завсарлага	ш	120	6000	720000		720000	Кофе, Цай, Сэндвич
3	Сургалтын заалны түрээс	цаг	6	20000	120000	120000		
	НИЙТ			50000	3720000	3000000	720000	